*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН С.ОЮУНДОЛГОРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.1 “ Төсвийн орлогын төслийг боловсруулах, хуваарилах, хэрэгжилтийг хангуулах болон төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.1 Төсвийн орлогыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, хуваарилах, биелэлтэнд хяналт тавих, Сар бүр татварын байцаагчтай орлогын мэдээг тулган баталгаажуулж, гүйцэтгэлд хяналт тавих | Орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | 100% | 100% | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 23/14 дугаар “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай”, 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 29/01 дугаар “Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” тогтоолоор Аймгийн төсвийн орлогыг 8,212.5 тэр бум төгрөгөөр, Сумдын төсвийн орлогыг 33,117.5 тэр бум төгрөгөөр баталсан. 11 сарын байдлаар аймгийн төсвийн орлого 6,544.6 тэр бум төгрөг буюу 79.7 хувийн биелэлттэй, сумын төсвийн орлого 37,507.4 | 2024-06-16<br>2024-12-31 | 92.7% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэр бум төгрөг буюу 113 хувийн биелэлттэй байна. Аймгийн төсвийн төлөвлөгөөнөөс татварын бус орлогыг 4,217.0 тэр бум төгрөгөөр төлөвлөсөн боловч 11 сарын байдлаар 2,163.3 тэр бум төгрөг төвлөрч 51,3 хувийн биелэлттэй байна. Үүнээс хүүгийн орлого 1,069 тэр бум огт ороогүй, ногдол ашгийн орлого 50 хувь, бусад орлого 54 хувийн биелэлттэй гарч төлөвлөгөө биелэхгүй байх нөхцөлд хүргэж байна. Бусад орлогууд төлөвлөсөн дүнгээс давж биелсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.1.2<br>Орлогын нэр төрлийг нэмэгдүүлэх эх үүсвэрийн талаар судалж саналаа удирдлагад танилцуулах | Орлогын нэр төрөл нэмэгдэж төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | 100% | 100% | Одоогоор шинэ санал гараагүй. Аймгийн төсвийн орлого 11 сарын байдлаар 79.7 хувь, сумын төсвийн орлого 113 хувийн биелэлттэй байна | 2024-06-16<br>2024-12-31 | 92.7% |
| 3. | Арга хэмжээ 1.1.3<br>Улс, аймаг, орон нутгийн төсвийн орлогын мэдээг шилэн данс болон uvurkhangai.mn сайтад хугацаанд нь мэдээлнэ | Мэдээний тоогоор | 100% | 100% | Шилэн дансны тухай хуулийн дагуу шинэчилсэн https://info.shilendans.gov.mn/ цахим хуудсанд сар бүр байршуулах ёстой 24 мэдээллээс хугацаа болсон 21 мэдээллийг | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн дагуу цаг хугацаанд нь ил тод болгон бүрэн мэдээлсэн. 3 мэдээлэл хугацаа болоогүй байгаа. | | |
| **Зорилт 1.2 " Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, сургалт сурталчилгаа зохион байгуулах"** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.2.1<br>Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, иргэдийн судалгааг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх | Мэдээллийн сантай болж хяналт тавих боломж бүрдэнэ | 8 | 15 | Сум орон нутагт байгаа мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нарын судалгаа гаргах зорилгоор Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт албан тоот, судалгааны маягт хүргүүлсэн. Уг судалгаагаар сумдад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн хуулийн этгээд байхгүй. Аймгийн төвд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг болон эрхэлдэг байсан 19 иргэний судалгааг гаргаж МЗҮА-ны талаар мэдээлэл өгсөн. | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |
| 2. | Арга хэмжээ 1.2.2<br>Мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулах өргөдөл хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, гэрчилгээ олгох | Хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэгчийн тоо нэмэгдэж, хуулийн хэрэгжилт хангагдана | 7 | 10 | Шинээр 10 иргэн МЗҮА эрхлэхээр хүсэлтээ ирүүлсэн. Эдгээр 10 иргэний хүсэлтийг хүлээн авч Зөвшөөрлийн цахим системд бүртгэн, Аймгийн засаг даргын захирамжаар бүртгэлийн гэрчилгээ олгосон. Нийт манай аймгийн хэмжээнд 11 иргэн МЗҮА эрхлэгчээр бүртгүүлж бүртгэлийн гэрчилгээ авсан байна. | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |
| 3 | Арга хэмжээ 1.2.3.<br>Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжийг | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 60% | 100% | Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах байцаагчаар ахлуулсан ажлын хэсэгтэй | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих | | | | хамтран ББСБ, ХЗХ болон МЗҮА эрхлэгч нарт 2 удаа хуулийн хэрэгжилт болон иргэдийн гомдол саналын дагуу газар дээрх хяналт шалгалтыг хийсэн. Тус шалгалтаар нэг ББСБ, дөрвөн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нарт мөнгөн торгууль ногдуулан, цаашид МЗҮА-г зохицуулах тухай хуулийг мөрдөж ажиллах талаар болон бусад холбогдох журмын талаар мэдээлэл өгч ажилласан. | | |
| 4 | Арга хэмжээ 1.2.4<br><br>Иргэдэд санхүүгийн боловсрол олгох, цахим санхүүгийн бүтээгдэхүүний сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Сургалтыг үе шаттай тогтмол зохион байгуулснаар иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдэж цахим бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн байна. | 50 | 150 | Стандарт хэмжил зүйн газрын сорьцын хяналтын улсын байцаагчтай хамтран Түшиг худалдааны төвд үйл ажиллагаа явуулдаг үнэт эдлэлийн худалдаа эрхлэгч нарт " Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа" сэдэвт сургалт хийж 8 иргэн хамрагдсан.<br>Мөн олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өрхийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээл, үнэт цаас, хувьцааны тухай сургалтыг Насан туршийн суралцахуй төвийн санхүүгийн боловсролын сургагч багш нар, Гүүдсек ҮЦК- тай хамтран зохион байгуулж 300 иргэнд сургалт хийсэн | 2024-06-16<br><br>2024-12-31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.3 “Хууль тогтоомж, тогтоол шийвдэр бодлогын баримт бичигт тусгагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх”** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.3.1<br><br>Файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, бүрэн бүрдэлтэй нь байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Байгууллагын архивт баримтыг бүрэн хүлээлгэн өгсөн байна | 100% | 100% | Хэлтсийн 11 төрлийн нийт 29ш баримтыг стандартын дагуу эмхлэн цэгцэлж, үдэж дугаарлан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. | 2024-06-16<br><br>2024-12-31 | 100% |
| 2 | Арга хэмжээ 1.3.2<br><br>Хариуцсан албан тушаалийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, салбарын яам агентлаг болон дээд шатны байгууллагад хүргүүлэх хугацаатай мэдээ, тайлан, судалгааг нэгтгэн хүргүүлэх, үр дүнг тооцон ажиллах | Хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь | 100% | 100% | Өөрийн нэр дээр цохогдон ирсэн хугацаатай 1ш, хугацаагүй 1ш албан бичгийг шаардлагын дагуу боловсруулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Мөн сар бүрийн орлогын мэдээ болон шилэн дансны мэдээлэл, СЗХ-д хүргүүлдэг Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлж байна. | 2024-06-16<br><br>2024-12-31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>Үндэсний бичгийг гүнзгийрүүлэн судлах, сургалтанд хамрагдах | Үндэсний бичгийн чадвар дээшилнэ. | 60% | 80% | Монгол бичгийн гарын авлага цахим хуудсыг даган цахим сургалтанд хамрагдаж байгаа. | 2024-06-16 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн үндэсний бичгээр унших чадвараа ахиулах зорилгоор 9-р ангийн охинтойгоо хамтран эх уншиж унших чадвараа ахиулж байна. | 2024-12-31 | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Цахим санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэгээ дээшлүүлж цахим сургалтанд хамрагдах | Цахим санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг дээшилсэн байна | 50% | 80% | 11 сарын 29-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Хөрөнгийн зах зээл болон Үнэт цаасны зах зээлийн тухай ойлголт” сэдэвт цахим сургалтанд хамрагдсан. Мөн Монгол банкнаас зохион байгуулсан Санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдан сургагч багшийн батламж гардан авсан. | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |
| 3 | Арга хэмжээ 2.3<br>Байгууллага хамт олноос зохион байгуулах сургалт, арга хэмжээнд тогтмол оролцох | Цаг үеийн мэдээллээс хоцрохгүй байна | 100% | 100% | Байгууллага хамт олны зүгээс зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд тогтмол оролцон мэдээ мэдээлэл авч байгаа. | 2024-06-16<br>2024-12-31 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:** ......Нягтлан бодогч...... С.Оюунцэцэг [signature]

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*